



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/15/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/233
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.ДАВААХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга нь тайлант онд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах, орон нутгийн хөгжлийн бодлогод иргэдийн оролцоог хангаж, мэргэшсэн чадварлаг албан хаагчдыг төлөвшүүлэн, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг хуульд нийцүүлэн, үр ашгийг дээшлүүлэхийг эрхэм зорилго болгон ажилласан байна.

Төв аймгийн Лүн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 01-ний 02 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 55 зорилт 229 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 90,83%-тай буюу "Үр дүнтэй" гэж дүгнэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудал байна. Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 05-ны 10/84 тоот албан бичигт орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн 4,386,674.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 190,750.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан байна.

G/Архив/Албан бичиг 2023/ А4

19020419

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	921,166.70	525,611.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	350,244.40	186,892.90
33	АВЛАГА	321,636.60	255,845.60
35	БАРАА МАТЕРИАЛ	249,285.60	82,873.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,988,817.70	5,205,076.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,988,817.70	5,205,076.90
39200	Биет хөрөнгө	8,923,782.70	5,183,105.40
39300	Биет бус хөрөнгө	65,035.00	21,971.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,909,984.40	5,730,688.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,714.30	68,541.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,714.30	68,541.30
41300	Өглөг	4,714.30	68,541.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,905,270.10	5,662,147.20
51	Засгийн газрын хувь оролцоо	9,905,270.10	5,662,147.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,198,755.80	608,018.80
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,198,755.80	608,018.80
51200	Хуримтлагдсан үр дүн	4,828,105.00	4,695,803.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,878,409.40	358,324.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,909,984.40	5,730,688.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,956,325.70	2,237,360.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	235,156.80	422,337.50
110	Орлогын албан татвар	90,460.20	205,847.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	90,460.20	216,554.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-10,707.40
113	Хөрөнгийн албан татвар	44,884.40	66,111.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	99,812.30	150,379.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	906,833.80	905,506.50
120	Нийтлэг татварын бус орлого	906,833.80	905,506.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,814,335.00	909,516.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,013,623.60	1,859,836.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,911,061.40	1,495,375.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,572,895.30	1,454,050.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,540,806.90	342,171.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,928.60	46,812.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	488,354.50	521,778.10
2104	Хангамж, бараа материалын зардал	70,447.30	62,147.40
2105	Нормативт зардал	168,888.40	43,446.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,243.00	8,382.10
2107	Томилолт, зочны зардал	6,997.70	5,540.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,262.40	175,157.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,084,966.40	248,614.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,338,166.20	41,325.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	102,562.20	364,460.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-57,297.90	377,524.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,314.60	4,577,830.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-58,612.50	-4,200,306.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,520,947.90	1,687,962.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	235,156.80	422,337.50
110	Орлогын албан татвар	90,460.20	205,847.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	90,460.20	216,554.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-10,707.40
113	Хөрөнгийн албан татвар	44,884.40	66,111.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	99,812.30	150,379.30
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,166.70	13,027.70
1181	Газрын төлбөр	6,165.50	80,689.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	84,480.00	56,662.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	528,153.50	335,876.90
120	Нийтлэг татварын бус орлого	528,153.50	335,876.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,757,637.50	929,748.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,106,955.70	1,364,179.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,106,955.70	1,364,179.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,767,781.50	1,320,236.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,540,886.70	345,377.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,699.90	45,867.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	490,696.00	477,789.40
2104	Хангамж, бараа материалын зардал	65,161.80	39,303.20
2105	Нормативт зардал	134,540.30	47,423.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,733.70	16,260.70
2107	Томилолт, зочны зардал	7,061.70	5,540.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,407.80	177,571.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316,593.60	165,102.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,339,174.20	43,942.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	413,992.20	323,783.70
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	112,442.80	453,729.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,442.80	453,729.20
2200	Дотоод эх үүсвэрээр	112,442.80	453,729.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-112,442.80	-453,729.20
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-46,015.00	-33,406.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	46,015.00	33,406.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	255,534.40	-163,351.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	94,710.00	350,244.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	350,244.40	186,892.90

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,963,882.60	9,963,882.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,963,882.60	9,963,882.60
9	Тайлант үеийн үр дүн	-58,612.50	-58,612.50
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,905,270.10	9,905,270.10
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,905,270.10	9,905,270.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,989,082.70	-1,989,082.70
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,916,187.40	7,916,187.40
19	Тайлант үеийн үр дүн	-4,200,306.60	-4,200,306.60
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,662,147.20	5,662,147.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,848,401,800.00	1,673,229,137.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,248,087,100.00	1,196,505,208.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,215,289,600.00	1,164,881,224.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,602,800.00	345,377,567.72
210101	Үндсэн цалин	278,863,100.00	255,997,619.41
210102	Нэмэгдэл	82,638,200.00	68,200,182.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	3,064,000.00
210104	Урамшуулал	15,101,500.00	17,070,789.13
210105	Гэрээт ажлын хөлс	0	1,044,976.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,317,900.00	45,867,451.23
210201	Тэтгэврийн даатгал	35,253,500.00	32,391,790.95
210202	Тэтгэмжийн даатгал	3,766,200.00	3,565,453.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,012,700.00	2,842,551.90
210204	Ажилгүйдлийн даатгал	753,300.00	667,300.84
210205	Эрүүл мэндийн даатгал	7,532,200.00	6,400,354.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	477,568,300.00	476,603,483.00
210301	Гэрэл, цахилгаан	47,489,300.00	45,813,185.00
210302	Түлш, халаалт	424,252,300.00	429,927,898.00
210303	Цэвэр, бохир ус	5,826,700.00	862,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,047,000.00	38,046,390.00
210401	Бичиг хэрэг	3,838,400.00	3,765,036.00
210402	Тээвэр, шатахуун	24,052,900.00	24,052,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,255,700.00	2,328,454.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,900,000.00	7,900,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,200,000.00	13,700,000.00
210604	Урсгал засвар	15,200,000.00	13,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,554,000.00	5,540,400.00
210702	Дотоод албан томилолт	5,554,000.00	5,540,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	174,821,400.00	174,567,932.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,177,000.00	171,923,532.28
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	708,000.00	708,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,095,400.00	1,095,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	650,000.00	650,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	191,000.00	191,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,578,200.00	64,578,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,578,200.00	56,578,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	8,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,797,500.00	31,623,984.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,797,500.00	31,623,984.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,000,000.00	12,626,484.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,797,500.00	18,997,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,314,700.00	443,317,929.00
221001	Их засвар	14,320,600.00	15,000,000.00
223001	Бусад хөрөнгө	485,994,100.00	428,317,929.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000,000.00	33,406,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000,000.00	33,406,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,848,401,800.00	1,653,494,085.23
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	189,071,200.00	189,071,200.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	189,071,200.00	189,071,200.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,295,773,400.00	1,435,507,854.23
320001	Орон нутгийн төсвөөс	1,295,773,400.00	1,435,507,854.23
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	363,557,200.00	28,915,031.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000,000.00	28,915,031.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	263,557,200.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	32,501,361.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	12,766,309.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	42	42
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21
620003	Үйлчлэх ажилтан	21	21
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	21	21

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	398,962,867.90	111,335,606.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,962,867.90	100,924,306.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	309,084,967.90	55,044,163.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,619,562.00	1,185,900.00
210302	Түлш, халаалт	31,619,562.00	1,185,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,514,575.00	1,256,796.00
210401	Бичиг хэрэг	560,725.00	0
210402	Тээвэр, шатахуун	1,474,000.00	1,256,796.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,479,850.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	3,000,000.00
210604	Урсгал засвар	0	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	0
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	721,991.00	3,003,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	721,991.00	3,003,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	265,428,839.90	46,597,587.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	265,324,839.90	46,597,587.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,877,900.00	45,880,143.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,114,800.00	9,701,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	9,201,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,876,600.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,230,200.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,763,100.00	36,178,543.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	53,763,100.00	36,178,543.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	10,411,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	10,411,300.00
223001	Бусад хөрөнгө	0	10,411,300.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	398,962,867.90	111,335,606.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	398,962,867.90	111,335,606.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,543,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	341,549,779.00	109,576,506.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,870,088.90	1,759,100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Лүн сум нь сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах, орон нутгийн хөгжлийн бодлогод иргэдийн оролцоог хангаж, мэргэшсэн чадварлаг албан хаагчдыг төлөвшүүлэн, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг хуульд нийцүүлэн, үр ашгийг дээшлүүлэх эрхэм зорилготой.

Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр 42 зорилт 139 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр батлагдан, хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар 92,2 хувиар дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, нийгмийн даатгалын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг хийх ажлын төлөвлөгөө гарган нийт 11 ажлын хүрээнд 90,9%-ийн хэрэгжилттэй ажилласан байна. Үүнд: Байгууллагуудын ажлын цаг ашиглалт, үр дүнгийн гэрээний хэрэгжилт, ЗДТГ-ын өвс тэжээлийн зарцуулалт, СХС-ийн зээлийн эргэн төлөлт, Шилэн дансны мэдээ, мэдээлэлтийн байдал, Татварын орлогын төлөвлөгөөний хэрэгжилт, Үдийн цай хөтөлбөр, Сургууль, Цэцэрлэгийн хоолны ордер, хүүхдийн тоотой таарч буй эсэх, Төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа байдал зэрэгт жилийн хүрээнд удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,179,295.8 мянган төгрөгөөр буюу 57,8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	350,244.4	186,892.9	-163,351.5
Авлага	321,636.7	255,845.6	-65,791.1
Бараа материал	249,285.6	82,873.2	-166,412.4
Үндсэн хөрөнгө	8,988,817.7	5,205,076.9	3,783,740.9
Нийт хөрөнгө	9,909,984.4	5,730,688.6	4,179,295.8
Өр төлбөр	4,714.3	68,541.3	63,827.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,905,270.1	5,662,147.2	4,243,122.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,909,984.4	5,730,688.6	4,179,295.8

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 186,892.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 163,351.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 141,817.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 160,204.7 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 255,845.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 65,791.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 38,506.5 мянган төгрөг, Ойн ангийн 20,232.0 мянган төгрөг, эмийн эргэлтийн сангийн 9,658.3 мянган төгрөгийн авлагыг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82,873.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 166,412.4 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 190,750.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,205,076.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,783,740.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 4,386,674.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 5,730,688.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,243,122.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 4,652,556.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 186,892.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 163,351.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	350,244.4	186,892.9	-163,351.5
Төгрөг	350,244.4	186,892.9	-163,351.5
Төрийн сангийн харилцах	344,701.8	165,395.1	-179,306.7
Арилжааны банк дахь харилцах	5,542.6	21,497.8	15,955.2
Дүн	350,244.4	186,892.9	-163,351.5

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 165,395.1 мянган төгрөгийн 85,7 хувь буюу 141,817.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 53.1 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 7,7 хувь буюу 12,713.2 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 6,5 хувь буюу 10,811.0 мянган төгрөгийг БНСБС-ийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 21,497.8 мянган төгрөг арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл нь 179,306.7 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, өмнөх оноос 160,204.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 15,955.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 255,845.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 65,791.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	12.6	-	-12.6
Зээлийн хүүгийн авлага	19,589.2	20,525.1	935.9
Байгууллагаас авах авлага	73,086.7	3,199.3	-69,887.4
Хувь хүмүүсээс авах авлага	228,948.2	232,121.1	3,173.0
Дүн	321,636.7	255,845.6	-65,791.1

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 255,845.6 мянган төгрөгийн 98,7 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 1,3 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 98,7 хувь буюу 252,646.3 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн, 20,525.1 мянган төгрөгийн авлага нь хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлага, байгууллагаас авах 3,199.3 мянган төгрөгийн авлага нь эмийн эргэлтийн сан, ЗДТГ, ИТХ-ын авлага байна.

Авлага дансны үлдэгдэл оны эхнээс 65,791.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих сумын сургууль, эмнэлэг, цэцэрлэг, ойн анги, орон нутгийн хөгжлийн сангийн 67,018.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 82,873.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 166,412.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	62,438.3	18,940.1	-43,498.2
Тусгай зориулалттай материал	13,165.7	2,381.0	-10,784.7
Эм боох материал	49,272.6	16,559.2	-32,713.4
Хангамжийн материал	177,873.3	46,393.1	-131,480.2
Бичиг хэргийн материал	6,151.3	4,793.1	-1,358.3

Аж ахуйн материал	120,019.1	18,273.3	-101,745.8
Сэлбэг хэрэгсэл	517.0	5,110.0	4,593.0
Түлш, шатах тослох материал	2,800.0	-	-2,800.0
Хүнсний материал	5,948.3	-	-5,948.3
Бусад хангамжийн материал	42,437.6	18,216.7	-24,220.9
Мал амьтад	8,974.0	17,540.0	8,566.0
Дүн	249,285.6	82,873.2	-166,412.4

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 82,873.2 мянган төгрөгийн 47,9 хувийг ЗДТГ, 21,4 хувийг эмийн эргэлтийн сан, 25,6 хувийг ойн анги, 5,1 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 166,412.4 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 90,999.5 мянган төгрөг, Цэцэрлэгийн 19,270.4 мянган төгрөг, эрүүл мэндийн төвийн 75,964.6 мянган төгрөг, Соёлын төвийн 4,515.5 мянган төгрөг, нийт 190,750.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,205,076.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,783,740.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	8,923,782.7	5,183,105.4	-3,740,677.4
Барилга, байгууламж, орон сууц	5,931,076.4	1,725,250.5	-4,205,825.9
Авто-тээврийн хэрэгсэл	337,898.8	483,274.9	145,376.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	583,155.8	160,746.3	-422,409.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	372,071.4	73,936.8	-298,134.6
Зам гүүрний байгууламж	615,196.1	619,516.1	4,320.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,724.8	-	-15,724.8
Бусад үндсэн хөрөнгө	3,494,262.9	3,599,070.9	104,807.9
Ном	304,986.5	287,074.8	-17,911.8
Биет бус хөрөнгө	65,035.0	21,971.5	-43,063.5
Программ хангамж	4,665.2	1,382.7	-3,282.5
Бусад биет бус хөрөнгө	64,560.0	21,534.0	-43,026.0
Дүн	8,988,817.7	5,205,076.9	-3,783,740.9

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 98,2 хувь буюу 5,109,877.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 1,8 хувь буюу 93,386.4 мянган төгрөгийг ойн ангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,783,740.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 1,451,346.4 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 359,578.8 мянган төгрөгийн, Эмнэлгийн 633,998.5 мянган төгрөгийн, Соёлын төвийн 1,941,750.9 мянган төгрөгийн, нийт 4,386,674.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 68,541.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 63,827.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өр	-	2,855.1	2,855.1
Бараа үйлчилгээний зардлын өр	178.0	42,988.8	42,810.8
Байгууллагад төлөх өглөг	4,536.3	22,697.5	18,161.2
Дүн	4,714.3	68,541.3	63,827.1

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 68,541.3 мянган төгрөг болж, 63,827.1 мянган төгрөгөөр оны эхнээс нэмэгдсэн нь ЗДТГ-ын 25,279.3 мянган төгрөгийн, ойн ангийн 2,855.1 мянган төгрөгийн, ЕБС-ийн 11,819.1 мянган төгрөгийн, Соёлын төвийн 21,909.9 мянган төгрөгийн өглөг тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,662,147.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,243,122.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,198,755.8	608,018.8	-1,590,737.0
Хуримтлагдсан үр дүн	4,828,104.9	4,695,803.6	-132,301.4
Өмнөх үеийн үр дүн	4,886,717.4	8,896,110.2	4,009,392.8
Тайлант үеийн үр дүн	(58,612.5)	(4,200,306.6)	-4,141,694.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,878,409.4	358,324.9	-2,520,084.5
Дүн	9,905,270.1	5,662,147.2	-4,243,122.9

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,662,147.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,243,122.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 1,590,737.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 2,520,084.5 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 4,009,392.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 4,141,694.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Лүн сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд хүргүүлсэн орлого, зардлыг тооцоолол, төлөвлөгөөг ирүүлээгүй болно.

Төв аймгийн Лүн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн “сумын 2022 оны төсөв батлах тухай” 4 дугаар тогтоолоор 2022 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 666,431.7 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,839,128.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 666,431.7 мянган төгрөгөөр, нийт урсгал үйл ажиллагааны зардлыг 117,624.0 мянган төгрөгөөр бууруулан 629,341.7 мянган төгрөгөөр, орон нутгийн орлогын шилжих үлдэгдлээс 15,297.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 248,259.4 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 204,368.4 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 100,000.0 мянган төгрөгөөр нийт 1,848,401.2 мянган төгрөгөөр сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 06 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 666,431.7 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 629,341.7 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 204,368.4 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 248,259.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,520,510.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 85,002.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,544,437.3 мянган төгрөг буюу 92,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 119,848.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	100,567.5	92,995.3	7,572.2	92,5%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	815,393.9	705,582.3	109,811.6	86,5%
3	ЕБС-үйлчилгээ	190,557.0	189,557.0	1,000.0	99,5%
4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	52,968.7	51,503.9	1,464.8	97,2%
5	Соёл урлагийн үйлчилгээ	171,815.0	171,815.0	0	100,0%
6	ЭМТ-ийн үйлчилгээ	33,362.5	33,362.5	0	100,0%
7	Хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээ	266,215.3	266,215.3	0	94,8%
8	Хоршоо хөгжүүлэх сан	33,406.0	33,406.0	0	100,0%
	Дүн	1,664,285.9	1,544,437.3	119,848.6	92,8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 89,873.6 мянган төгрөг, ИТХ 1,230.0 мянган төгрөг, ойн анги 20,232.0 мянган төгрөг, нийт 111,335.6 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	92%	100,567.5	92,995.3
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	87%	815,393.9	705,582.3
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	171,815.0	171,815.0

4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	99,0%	190,557.0	189,557.0
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	97%	52,968.7	51,503.9
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	33,362.5	33,362.5
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	266,215.3	266,215.3
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	33,406.0	33,406.0

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт хангалттай байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 01/44 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Лүн сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 1,848,401.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 27,726.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 20,794.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 11 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл холбоотой 16 мэдээлэл байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдэж 1 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар гурван зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 03/221 албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	1	0	1	0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал тогтоогдоогүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 818,762.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 818,762.5 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардал үндсэн хөрөнгийг 818,762.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 101,133.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 101,133.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 687,387.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 719,611.4 мянган төгрөг төвлөрсөн ба 16 нэр төрлийн орлогоос 8 нэр төрлийн орлого 101,133.8 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх, татварын байцаагчийг тогтвор суурьшилтай үр дүнтэй ажиллуулах талаар аймгийн Татварын хэлтэст мэдэгдэх

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд байршуулбал зохих мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээлли йг тусгахгүй орхигдуул сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагү й			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	818,762.5			1	818,762.5	1	818,762.5				
ЗДТГ	1	730.0			1	730.0	1	730.0				
Дүн	1	819,492.5			1	819,492.5	1	819,492.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	1	101,133.8					1	101,133.8				
ЗДТГ	5	49,302.0	1	1,521.2	2	27,830.8	2	19,950.0				
ИТХ												
Дүн	6	150,435.8	1	1,521.2	2	27,830.8	3	121,083.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг дутуу байршуулсан	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0					1	0